



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/626

Мөрөн сум

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийг 30.1.6, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай 02 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Гишүүд: Төрийн байгууллагын төлөөлөл:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ажилтны эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлын төлөөлөл:

-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Ц.Ганболд

- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч, залуучуудын хорооны дарга Б.Баасандорж

- Аймгийн Хөгжимт драмын театрын үйлдвэрчний хорооны дарга М.Гонгорсүрэн

Ажил олгогчийн төлөөлөл: • Н.Отгонбаяр (Идэр зөөлөн ХХК-ны захирал)

-Б.Баярмагнай (Шар царам ХХК-ны менежер)

-А.Дашзэвэг (Идэр нумт ХХК-ны захирал)

Нарийн бичгийн дарга:

- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

2.Хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомж, төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, төслийн үр дүн нөлөөлөлд үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаж ажиллахыг зөвлөлийн гишүүд, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга (Т.Раднаабүд)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны "Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл шинэчлэн байгуулах тухай" А/531 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011973